



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 4/03

Жаргалтхаан сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийн 5.3 дахь заалт, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэгийн дотоод журмын 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цэцэрлэгийн багш, ажилчны ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай

Үүнд: Зөвлөлийн даргаар багш	Б.Сэргэлэн
Нарийн бичиг: Нярав	Б.Ариунчимэг
Гишүүн: Багшийн туслах	Р.Энхсаруул

2. Ёс зүйн дэд хорооны ажиллах ажлын төлөвлөгөө, журам, дүрмийг боловсруулан батлуулах, нийт ажилчдад таниулах, сургалт зөвлөгөөг тогтмол зохион байгуулж улирал тутам тайланг илтгэх хуудсаар өгч ажиллахыг тус хорооны дарга (Б.Сэргэлэн)-д үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны ажилд хяналт тавьж ажиллахыг цэцэрлэгийн аргазүйч (Т.Энхнаран)-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ



Д.ӨНӨРЖАРГАЛ